



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/64

Улаанбаатар хот

Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын  
хэрэгжилтийг хангах Ажлын хэсэг  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.7 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 9.5 дахь зорилт, Засгийн газрын 2022 оны 419 тогтоолын 4 дэх заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч дүүргийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээний 3.30 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах чиглэлээр холбогдох судалгаа хийх, санал, төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөө, судалгааг чанартай, үр дүнтэй зохион байгуулж, саналыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох дээд шатны байгууллагад танилцуулахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т үүрэг болгосугай.


3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023 оны 03 сарын 31-ны өдрийн 1/69 дугаар  
захирамжийн хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Болормаа	Дүүргийн Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
	Гишүүд:	Б.Отгонжаргал Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Ц.Мягмарсүрэн	Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Б.Цогжавхлан	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Д.Хүрэлбаатар	Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
	Ч.Магадсайхан	Газар зохион байгуулалтын албаны дарга
	Ц.Жамбалцэрэн	Багахангайн үйлдвэрлэл технологийн парк ОНӨТҮГ-ын дарга
	Д.Энхтайван	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга
	М.Уранцэцэг	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
	Х.Анхбаяр	Татварын хэлтсийн дарга
	М.Өсөхдэлгэр	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн дарга
	И.Батнасан	Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Батхуяг	Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн Дэд бүтэц, Тохижилт, Орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн